



Г САНГИЙН САЙД Б.ЧОЙЖИЛСҮРЭН Г  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД**

14251 Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,  
Утас: 6226-3168, Факс: (976-11) 31-23-15,  
E-mail: info@mrtд.gov.mn, http://www.mrtд.gov.mn

2017.01.07 № 01/88

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Монгол Улсын эдийн засаг, нийгмийг Г  
2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн  
биелэлтийн тайлан хүргүүлэх тухай


Улсын Их Хурлын 2015 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн сайдын 2016 оны 137 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 9 зорилтыг хэрэгжүүлэх 23 арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам", Зам, тээврийн сайдын 2014 оны 116 дугаар тушаалаар баталсан "Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, төлөвлөгөөний хэрэгжилтийг хүргүүлж байна.

Хавсралт 15 хуудастай.

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан 3 хуудас;
2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 12 хуудас.

САЙД



Д.ГАНБАТ

Боловсруулсан: Н.Буянт  
Нийлсэн *N. Buyant*  
2% Ц.Н  
2017.01.06



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ  
 ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
 ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

/Жилийн эцсийн байдлаар/

**Нэг. Танилцуулга**

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн сайдын 2016 оны 137 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Тус төлөвлөгөөнд Зам, тээврийн салбарт 9 зорилтыг хэрэгжүүлэх 23 арга хэмжээ төлөвлөсөн. Үүнд:

- Авто замын салбарт 4 зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээ
- Төмөр замын тээврийн салбарт 3 зорилтыг хэрэгжүүлэх 9 арга хэмжээ
- Агаарын тээврийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 1 арга хэмжээ
- Автотээврийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 1 арга хэмжээ

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, Зам, тээврийн сайдын 2014 оны 116 дугаар тушаалаар баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ын дагуу Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 23 арга хэмжээний хэрэгжилтийг 2016 оны жилийн эцсийн дүнгээр авч үзвэл 4 арга хэмжээг үнэлэх боломжгүй байгаа ба бусад 19 арга хэмжээ **дунджаар 77.9 хувийн биелэлттэй** дүгнэгдлээ. Хэрэгжилтийг газар, хэлтэс тус бүрээр авч үзвэл:

№		Нийт заалт	Биел -сэн	Биелээгүй						Дүгнэгдэх боломжгүй	Хувь
				90	70	50	30	10	0		
1	БТГ	12	-	4	3	2	-	-	-	3	74.4%
2	АЗБХЗГ	12	3	3	2	2	-	-	-	2	81%
3	АТБХЗГ	1	-	1	-	-	-	-	-	-	90%
4	ТЗДТБХЗГ	9	-	3	2	2	-	-	-	2	72.9%
5	ХШҮДАГ	3	-	-	-	-	-	-	-	3	-
6	АТБХЗХ	1	-	-	1	-	-	-	-	-	70%
<b>Нийт</b>		<b>23</b>	<b>3</b>	<b>7</b>	<b>5</b>	<b>4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>77.9%</b>

**Хоёр. Дүгнэлт**

**Агаарын тээврийн салбарт** Даланзадгад, Ховдын нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгон өргөжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх Барилгын ажлын явц /10 хувиар/ арга хэмжээ нь 70 хувийн биелэлттэй дүгнэгдлээ.

**Авто тээврийн салбарт** Нийтийн тээврийн үйлчилгээнд тусгай замын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх төслийг эхлүүлэх зорилтыг хэрэгжүүлэх Бэлтгэл ажлын явц /100 хувиар/ арга хэмжээ 90 хувийн биелэлттэй дүгнэгдлээ.

**Төмөр замын салбарт** хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 9 арга хэмжээнээс 7 арга хэмжээ 72.9 хувьтай дүгнэгдэж, 2 арга хэмжээ дараах шалтгаанаар хэрэгжээгүй байна. Үүнд:

1. *Мандал-Багахангай чиглэлийн Богдхан төмөр замын суурь бүтэц барих төслийг эхлүүлэх* зорилтыг хэрэгжүүлэх ажлын *Барилгын ажлын явц /5 хувиар/* арга хэмжээ: Судалгаа болон техник эдийн засгийн үндэслэл хийгдсэний дараа эхэлнэ. Судалгааны ажил хийх санхүүжилтийг АХБ-аас гаргахаар шийдвэрлэсэн. Монгол Улсын 2016, 2017 оны төсвийн тухай хуульд Зам, тээврийн сайдын багцад барилгын ажлын санхүүжилт тусгагдаагүй тул бусад хөрөнгө оруулагчдад хандаад байна.

2. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг үргэлжлүүлэх ажлын Сайншанд-Хөөт чиглэлийн /431км/ *Барилгын ажлын явц /10 хувиар/* арга хэмжээ: Засгийн Газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын I болон II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг "Монголын Төмөр Зам" ТӨХК-д олгосон. Энэ хүрээнд Япон Улсын "Nippon koei" компанийг техникийн зөвлөхөөр сонгон ажиллуулж Тавантолгой-Сайншанд, Сайншанд-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан чиглэлийн төмөр замын чигийг тогтоох, байр зүйн зураг, геотехник, гидрогеологи, археологи, палеонтологи, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх, техникийн зураг төслийг боловсруулах ажлыг 100% гүйцэтгээд байна. Таван толгой-Сайншанд-Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын шугамын чигийг тогтоох тухай тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 146 дугаар тогтоолоор батлуулсан. Сайншанд-Хөөт чиглэлийн төмөр зам нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл мөн "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тус тус тусгагдаагүй тул тодорхой ажил хийгдээгүй байна.

**Авто замын салбарт** хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 12 арга хэмжээнээс 10 арга хэмжээ 81 хувьтай дүгнэгдэж, 2 арга хэмжээ дараах шалтгаанаар хэрэгжээгүй байна. Үүнд:

1. *Азийн авто замын сүлжээнд холбогдсон АН-4 чиглэлийн авто замын сүлжээг барьж, ашиглалтад оруулах* зорилтыг хэрэгжүүлэх *Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын* гэрээг 2015 оны 08 сарын 31-ний өдөр "Чайна Хуаши Ентерпрайзис Лимитэд" компанитай байгуулсан бөгөөд 2017 оны 08 сарын 30-ны өдөр авто замыг ашиглалтад оруулахаар гэрээнд заасан.

Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад гомдол гарсан бөгөөд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байна. Шүүхийн шийдвэр гарсны дараа барилгын ажил эхэлнэ.

Зам барилгын ажлын бэлтгэл ажлыг хангах хүрээнд ажиллах хүчний зөвшөөрөл, тоног, төхөөрөмж, машин механизмыг гааль, НӨАТ-аас чөлөөлүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлсэн. Мөн Засгийн газрын тогтоолоор тус чиглэлийн авто замд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлүүлэх шийдвэрийг гаргуулан ажиллав. Барилгын ажил эхлэх бэлтгэлийг хангасан.

2. *Ховдоос Завханы чиглэлийн Сархайрханы гүүр хүртэлх 130 км хатуу хучилттай замыг барих асуудлыг судалж шийдвэрлэх* зорилтыг Монгол Улсын

эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тус яамнаас санал оруулаагүй. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эхний ээлжид аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох зорилтыг тавьсан бөгөөд энэхүү зорилтод дээрх чиглэлийн авто зам тусгагдаагүй. Тус чиглэлийн авто замын судалгааны ажлыг боловсруулахад шаардагдах хөрөнгө Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй тул хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн.

### **Гурав. Санал**

*Азийн авто замын сүлжээнд холбогдсон АН-4 чиглэлийн авто замын сүлжээг барьж, ашиглалтад оруулах/189.7 км/ зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:*

Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд 2014 оны 06 сарын 04-ний өдөр байгуулсан МОН-3129 Зээлийн гэрээний дагуу “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн 2 дугаар үе шатны ажлын хүрээнд Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн нийт 189.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажил хэрэгжиж байна. Зам барилгын ажлын бэлтгэл ажлыг хангах хүрээнд ажиллах хүчний зөвшөөрөл, тоног, төхөөрөмж, машин механизмыг гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлсэн. Мөн Засгийн газрын тогтоолоор тус чиглэлийн авто замд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлүүлэх шийдвэрийг гаргуулсан.

Зам барилгын ажлын гүйцэтгэгч /Хашаатын даваа-Шурагийн гүүр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гэрээг “Чайна Хуаши Ентерпрайзис Лимитэд” компанитай, Шурагийн гүүр-Ховд чиглэлийн 53.9 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гэрээг “НКВ интернайшнл холдинг” ХХК-тай, Хашаатын даваа-Толбо сум чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гэрээг “Чайна Хуаши Ентерпрайзис Лимитэд” компанитай байгуулсан/-ийг олон улсын тендерээр 2015 оны 07 дугаар сард сонгон шалгаруулсан бөгөөд ажил гүйцэтгэх гэрээг 2015 оны 08 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан. Гэрээнд зааснаар 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр авто замыг ашиглалтад оруулах ба батлагдсан төлөвлөгөөгөөр тус чиглэлийн Багц 1, Багц 2, Багц 3 хэсгийн барилгын ажлын 30 хувийг энэ онд хийж гүйцэтгэх тул 8.2 зорилтыг Азийн авто замын сүлжээнд холбогдсон АН-4 чиглэлийн авто замын сүлжээг барих зам, барилгын ажлыг хэрэгжүүлэх, 2016 онд хүрэх төвшин, үр дүнг 30% болгон өөрчлөн дүгнүүлэх саналтай байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД  
ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУССАН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2016 оны 12 р сарын 28-ны өдрийн байдлаар

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2016 онд хүрэх түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс	Хэрэгжилт	Нийт хувь
1	2	3	4	5	6	7	8
<b>НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>							
<b>Зорилт 8. Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн тээврийн салбарыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.</b>							
8.1	ҮХЦБ-ын 5.3.1.7 дахь зорилт, ЗГҮАХХАХТ-ний 220.2 дахь заалт	Нийтийн тээврийн үйлчилгээнд тусгай замын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх төслийг эхлүүлэх	Бэлтгэл ажлын явц, хувиар	100 хувь	АТБХЗГ БТГ	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх "Тусгай замын автобусны төсөл"-ийн хөрөнгө оруулалтын гэрээг соёрхон батлах тухай хуулийг УИХ-ын 2015.04.30-ны өдрийн чуулганаар хэлэлцүүлэн батлуулав. Уг төслийг Азийн хөгжлийн банкны 59.9 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, Дэлхийн байгаль орчны байгууллагын 1.5 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 17 сая ам.долларын хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн. 2015 оны 7 сарын 03-ны өдрийн НИТХТ-ийн 130 дугаар тогтоолоор Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дүрмийг баталсан. НИТХТ-ийн 2015 оны 131 дугаар тогтоолоор "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр /BRT/ төсөл"-ийн үйл ажиллагааг удирдаж чиглүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг баталсан. Нийслэлийн Засаг даргын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/741 дугаар захирамжаар Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр" BRT /Bus rapid transit/-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг сонгон шалгаруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан ба 2016 оны 12 дугаар сард Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж, үйл	90%

						ажиллагааг эхлүүлнэ. Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/154 захирамжаар "Нийслэлийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн бэлтгэл ажлыг хангах, Азийн хөгжлийн банкны төслийн баг, судалгааны багуудын ажлыг дэмжих, шуурхай зохицуулалтаар хангах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад холбогдох техникийн шийдлийг гаргаж хамтран ажиллах үүрэг бүхий Техникийн ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсэг АХБ-ны төслийн баг, Нийтийн тээврийн чадавхыг бэхжүүлэх ТА8212-МОН болон Төр хувийн хэвшлийн түншлэлийн бэхжүүлэх ТА8985-МОН төслийн багтай уулзалт хийж АХБ-ны тусгай замын автобусны коридорыг сонгох талаар ажиллаж байна.	
8.2	ҮХЦБ-ын 5.3.1.2 дахь зорилт, Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр /цаашид "ШББДХЗХ" гэх/-ийн 4.4.2.10 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 112 дахь заалт	Азийн авто замын сүлжээнд холбогдсон АН-4 чиглэлийн авто замын сүлжээг барьж, ашиглалтад оруулах	1. Хашаатын даваа-Шурагийн гүүр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэх  2. Шурагийн гүүр-Ховд чиглэлийн 53.9 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэх	189.7 км	АЗБХЗГ ХШУДАГ	Тус чиглэлийн авто замын барилгын ажлын гэрээг 2015 оны 08 дугаар сарын 04-ний өдөр "Чайна Хуаши Ентерпрайзис Лимитэд" компанитай байгуулсан бөгөөд барилгын ажлын гэрээгээр 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр авто замыг ашиглалтад оруулна. 2016 оны зам барилгын ажил 5 дугаар сард эхэлсэн, барилгын ажил 11 дүгээр сарыг хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Энэ онд нийт ажлын 30 хувийг хийх төлөвлөгөөтэй, одоогоор хөрс хуулалт 85,71%, далангийн дүүргэлт 66,7%, ухмал 14,58%, суурийн доод үе 42.53% хийгдсэн. Нийт барилгын ажил 17.20%-тай байна.  Зам барилгын ажлын бэлтгэл ажлыг хангах хүрээнд ажиллах хүчний зөвшөөрөл, тоног, төхөөрөмж, машин механизмыг гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлсэн. Мөн Засгийн газрын тогтоолоор тус чиглэлийн авто замд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлүүлэх шийдвэрийг гаргуулан ажиллав.	50%
						Тус чиглэлийн авто замын барилгын ажлын гэрээг 2015 оны 08 дугаар сарын 4-ний өдөр "НКВ интернайншл холдинг" ХХК-тай байгуулсан бөгөөд барилгын ажлын гэрээгээр 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр авто замыг ашиглалтад оруулна. 2016 оны зам барилгын ажил 5 дугаар сард эхэлсэн, барилгын ажил 11 дүгээр сарыг хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Энэ онд нийт ажлын 30 хувийг хийх төлөвлөгөөтэй, одоогоор хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 79,57%, ухмал 96,93%, суурийн доод үе 72.28%, гүүрийн ажил 30.54%, хоолойн ажил 23.05% хийгдсэн. Нийт барилгын ажил 27.44%-тай байна.  Зам барилгын ажлын бэлтгэл ажлыг хангах хүрээнд ажиллах	70%

						хүчний зөвшөөрөл, тоног, төхөөрөмж, машин механизмыг гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлсэн. Мөн Засгийн газрын тогтоолоор тус чиглэлийн авто замд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлүүлэх шийдвэрийг гаргуулан ажиллав.	
			3. Хашаатын даваа-Толбо сум чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэх			Тус чиглэлийн авто замын барилгын ажлын гэрээг 2015 оны 08 дугаар сарын 04-ний өдөр "Чайна Хуаши Ентерпрайзис Лимитэд" компанитай байгуулсан бөгөөд барилгын ажлын гэрээгээр 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр авто замыг ашиглалтад оруулна. 2016 оны зам барилгын ажил 6 дугаар сард эхэлсэн, барилгын ажил 11 дүгээр сарыг хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Энэ онд нийт ажлын 30 хувийг хийх төлөвлөгөөтэй, одоогоор хөрс хуулалт 38,28%, далангийн дүүргэлт 14.10%-тай байна. Нийт барилгын ажил 7.22%-тай байна. Зам барилгын ажлын бэлтгэл ажлыг хангах хүрээнд ажиллах хүчний зөвшөөрөл, тоног, төхөөрөмж, машин механизмыг гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлсэн. Мөн Засгийн газрын тогтоолоор тус чиглэлийн авто замд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлүүлэх шийдвэрийг гаргуулан ажиллав.	50%
			4. Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэх			Тус чиглэлийн авто замын барилгын ажлын гэрээг 2015 оны 08 дугаар сарын 31-ний өдөр "Чайна Хуаши Ентерпрайзис Лимитэд" компанитай байгуулсан бөгөөд барилгын ажлын гэрээгээр 2017 оны 8 сарын 30-ны өдөр авто замыг ашиглалтад оруулна. Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад гомдол гарсан бөгөөд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байна. Шүүхийн шийдвэр гарсны дараа барилгын ажил эхэлнэ. Зам барилгын ажлын бэлтгэл ажлыг хангах хүрээнд ажиллах хүчний зөвшөөрөл, тоног, төхөөрөмж, машин механизмыг гааль, НӨАТ-аас чөлөөлүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлсэн. Мөн Засгийн газрын тогтоолоор тус чиглэлийн авто замд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлүүлэх шийдвэрийг гаргуулан ажиллав. Барилгын ажил эхлэх бэлтгэлийг хангасан.	
8.3	ҮХЦБ-ын 5.3.1.2 дахь зорилт, "ШББДХЗХ"-ийн 4.4.2.10	Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто	1. Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км хатуу хучилттай авто	483 км	АЗБХЗГ	Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127км авто замын дутуу тусгагдсан хөрөнгийн асуудлыг Засгийн газарт танилцуулан, 2016 оны 195 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. 2016 оны төсвийн тодотголоор 5.9 тэрбум төгрөг дутуу тусгагдсан тул барилгын ажлыг гэрээт хугацаанд нь бүрэн дуусган ашиглалтад өгөх	90%



дахь заалт, ЗГҮАХХАХТ- ний 108.1, 108.4 108.8, 108.11 дэх заалт	замаар холбох	замын барилгын ажил			боломжгүй болсон. Барилгын ажлын явц 93.7%-тай байна.	
		2. Элсэнтасархай -Хархорины Орхоны гүүр чиглэлийн 77 км хатуу хучилттай авто замын их засвар, шинэчлэлтийн ажил			Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Элсэнтасархай-Хархорины Орхоны гүүр чиглэлийн 77 км хатуу хучилттай авто замын их засварын ажил 2016 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр дууссан. Замын чанар байдлыг тогтоож, дүгнэлт гаргасан. Улсын комисс 2016 оны 11 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд ажиллаж ашиглалтад авсан.	100%
		3. Ховдын Булган-Үенч чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын барилгын ажил			Булган – Үенч - Ховд чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын хөрөнгийн эх үүсвэрийн шийдвэрлэх асуудлыг Засгийн газрын 195 дугаар тогтоолоор батлуулсан. Тус тогтоолоор Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан "Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2015 онд Хөгжлийн банкнаас санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын 142-т заасан "Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн авто замын барилга (60 км)" ажлын төсөвт өртгийг 18,173.6 (арван найман тэрбум нэг зуун далан гурван сая зургаан зуун мянган) сая төгрөгөөр тус тус тогтоож, 2016 оны төсвийн тодотголын төсөлд тусгахаар шийдвэрлэсэн боловч 2017 оны улсын төсөвт тусгагдсан. 2016 онд санхүүжилтгүйн улмаас тус чиглэлийн авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүйд хүрсэн. Гүйцэтгэгчтэй нэмэлт гэрээг байгуулсан. Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр 4.0 орчим тэрбум төгрөгийн ажлыг хийсэн. Барилгын ажил 86.5%-тай. Барилгын ажлыг 2017 онд үргэлжлүүлнэ.	90%
		4. Өндөрхаан- Чойбалсан чиглэлийн 143 км хатуу хучилттай авто замын барилгын ажил			Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гэрээг "Насны зам" ХХК, "Бадрах ойл" ХХК, "Өвөрзалаат" ХХК, "Хансуун зам" ХХК, "Арж капитал" ХХК-тай байгуулан Хөгжлийн банканд хүргүүлсэн. Багц 1-ын 52.74км авто зам, багц 4-ын 25км авто замуудад Улсын комисс ажилласан.Багц 2-ын 23.32 км авто зам, багц 5-ын 27.98 км авто замуудад чанар байдлын дүгнэлт гаргасан. Улсын комисс ажиллахаар төлөвлөж байна. Багц 3-ын 13.32 км авто замаас 3 км замын хучилт хийгдээгүй үлдээд байна. Барилгын ажлын явц 95%.	90%
		5. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын дунд тойргийн 9.8 км			Уг авто замын барилгын ажил бүрэн дууссан. Улсын комисс 2016 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр ажилласан. Акт баталгаажих шатандаа явж байна	100%

			хатуу хучилттай авто				
			6. Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам			Тосонцэнгэл - Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын санхүүжилтийн асуудлыг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хэмнэгдсэн хөрөнгөөс шийдвэрлүүлэхээр Засгийн газарт танилцуулан 2016 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 44 дүгээр хуралдааны тэмдэглэл гарсан боловч эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Барилгын ажил 60%-тай	70%
8.4	ҮХЦБ-ын 5.3.1.3 дахь зорилт	Улсын чанартай авто замын сүлжээний ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах	Засвар, арчлалт хийгдэх авто замын сүлжээний урт, мян.км	12.7 мян.км	АЗБХЗГ	Олон улсын болон улсын чанартай авто зам, гүүрийн засвар, арчлалтын ажлын 2016 оны төлөвлөгөөг зам хариуцагч 28 компанийн хариуцдаг авто замыг чиглэл тус бүрээр, хучилтын төрөл, насжилт, хөдөлгөөний эрчимтэй уялдуулж, өвлийн улиралд ажиллах шуурхай ажлын хэсгүүдийн байршил, ажиллах хүч, машин, механизм, гүүрийн хамгаалагч-засварчин ажиллуулах гүүрнүүдийн байршил, цалингийн зардлыг тус бүрд нь боловсруулан тооцож Зам, тээврийн сайдын /хуучнаар/ 2016 оны 21 тоот тушаалаар, нэмэлтээр батлагдсан 12.0 тэрбум төгрөгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 43 дугаар тушаалаар шинэчлэн тус тус батлуулсан. Батлагдсан тушаалыг хэрэгжүүлэн ажиллахаар бүс нутаг хариуцсан мэргэжилтнүүд газар дээр нь ажиллан, хийгдэх зам засварын ажлын тоо хэмжээг тогтоож, график төлөвлөгөө, төсвийг гарган баталж, засварын ажлыг хийж гүйцэтгүүлж байна. Засвар арчлалт ажил 100%.	100%
8.5	ҮХЦБ-ын 5.3.1, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого /цаашид "ТТЗТТББ" гэх/-ын 3.2.2, 3.2.4 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 107.1 дэх заалт	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг үргэлжлүүлэх	1. Тавантолгой-Сайншанд чиглэлийн /446 км/	10 хувь	ТЗДТБХЗ Г, БТГ	Засгийн Газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын I болон II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг "Монголын Төмөр Зам" ТӨХК-д олгосон. Энэ хүрээнд Япон Улсын "Nippon koei" компанийг техникийн зөвлөхөөр сонгон ажиллуулж Тавантолгой-Сайншанд, Сайншанд-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан чиглэлийн төмөр замын чигийг тогтоох, байр зүйн зураг, геотехник, гидрогеологи, археологи, палеонтологи, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх, техникийн зураг төслийг боловсруулах ажлыг 100% гүйцэтгээд байна. Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ 2015 оны 08 дугаар сард Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэр Японы тал Тавантолгой-Сайншанд, цаашлаад Сайншанд-Хөөт-Чойбалсан-Эрээнцав чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад оролцох сонирхолтойгоо илэрхийлж, хоёр тал хамтран ажиллах эрмэлзлээ нотолсон харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Энэ хүрээнд Японы тал дээрх чиглэлийн дагуу 2011	70%

					<p>онд боловсруулсан урьдчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг өнөөдрийн эдийн засгийн, олон улсын зах зээлийн нөхцөл байдалд уялдуулан дахин шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна. Судалгааны ажлын үр дүнд үндэслэн Тавантолгой-Сайншанд, цаашлаад Сайншанд-Хөөт-Чойбалсан-Эрэнцав чиглэлийн төмөр замын барилгын ажлыг энэ онд багтаан эхлүүлэхээр ажиллаж байна. Таван толгой-Сайншанд чиглэлийн төмөр замын ажлын нарийвчилсан зураг төслийг Япон Улсын "Nippon koei" компаниар гүйцэтгүүлэхээр хэлэлцээ хийж байна. Таван толгой-Сайншанд-Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын шугамын чигийг тогтоох тухай тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 146 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>Монгол Улсын зүүн бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд хэрэгжүүлэх Монгол, Япон хоёр орны засгийн газрын хооронд Тавантолгой-Сайншанд чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх арга зам, хөрөнгө оруулалтын яриа хэлэлцээг тогтмол хийж байна. Японы ерөнхий сайд Шинзо Абэ-гийн 2015 оны 10 дугаар сард Монгол улсад хийсэн айлчлалын үеэр хоёр орны Засгийн газар хооронд "Монгол болон Япон Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг" /22.10.2015/ байгуулсан бөгөөд энэхүү санамж бичигт ТТ-СШ чиглэлийн төмөр замын төслийн асуудлыг тодорхой тусгасан болно. Энэ ажлын хүрээнд "JBIC" /Японы олон улсын хамтын ажиллагааны банк/-ны санхүүжилтээр "PwC" нь Зүүн төмөр замын төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж эдийн засгийн үр ашгийн талаар судалгааг хийж Монголын талд хүлээлгэн /31.05.2016/ өгсөн. Тус судалгаа нь дэлхийн нүүрсний зах зээлийн хандлага (2020 он хүртэлх) болон Тавантолгойн ордын нүүрсний өрсөлдөх чадварыг судалсны үндсэн дээр Тавантолгойн нүүрсийг Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Сайншандын чиглэлийн төмөр замаар тээвэрлэн Гашуунсухайт, Замын-Үүд, Сүхбаатарын боомт хүргэж БНХАУ, ОХУ-ын төмөр зам, далайн боомтуудыг ашиглан Япон, Солонгос улсуудад гаргах хувилбарын талаар эдийн засгийн дүгнэлт хийсэн бөгөөд энэхүү судалгаанд авч ашиглах тодорхой бодлого, хөтөлбөр байхгүйн улмаас зөвхөн одоо байгаа ачаа тээврийн эргэлт дээр үндэслэн боловсруулсан нь эдийн засгийн хувьд үр ашиггүй гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Иймд шинээр хийгдэх Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг, Уул уурхай, Аж үйлдвэрийн бодлого зэрэг бодитой шийдвэр дүгнэлтийг үндэслэн зүүн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-г дахин боловсруулах</p>
--	--	--	--	--	--

					шаардлага гарч байна. Түүнчлэн Япон улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл"-тэй адил нөхцөлөөр Зүүн чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх боломжийг судалж Монгол Улсын Засгийн газраас Япон Улсын засгийн газарт албан ёсны хөнгөлөлттэй зээлийн хүсэлтийг гаргаж, 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг идэвхжүүлэхээр ажиллаж байна. Түүнчлэн Шинэ төмөр зам төслийн хүрээнд Таван толгой-Сайншанд, Сайншанд-Хөөт чиглэлийн төмөр замын төслийг Зүүн босоо коридор буюу Бичигт-Хөөт, Хөөт-Чойбалсан-Эрээн цав чиглэлийн төмөр замтай уялдуулан хөгжүүлэх талаар эдийн засгийн үр ашгийн тооцоо, судалгааг хийх шаардлага гарч байна.	
			2. Сайншанд-Хөөт чиглэлийн /431км/		Засгийн Газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын I болон II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг "Монголын Төмөр Зам" ТӨХК-д олгосон. Энэ хүрээнд Япон Улсын "Nippon koei" компанийг техникийн зөвлөхөөр сонгон ажиллуулж Тавантолгой-Сайншанд, Сайншанд-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан чиглэлийн төмөр замын чигийг тогтоох, байр зүйн зураг, геотехник, гидрогеологи, археологи, палеонтологи, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх, техникийн зураг төслийг боловсруулах ажлыг 100% гүйцэтгээд байна. Таван толгой-Сайншанд-Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын шугамын чигийг тогтоох тухай тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 146 дугаар тогтоолоор батлуулсан. Сайншанд-Хөөт чиглэлийн төмөр зам нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл мөн "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тус тус тусгагдаагүй тул тодорхой ажил хийгдээгүй байна.	-
			3. Чойбалсан-Хөөт чиглэлийн /194км/		Засгийн Газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын I болон II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг "Монголын Төмөр Зам" ТӨХК-д олгосон. Энэ хүрээнд Япон Улсын "Nippon koei" компанийг техникийн зөвлөхөөр сонгон ажиллуулж Тавантолгой-Сайншанд, Сайншанд-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан чиглэлийн төмөр замын чигийг тогтоох, байр зүйн зураг, геотехник, гидрогеологи, археологи, палеонтологи, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх, техникийн зураг төслийг боловсруулах ажлыг 100% гүйцэтгээд байна. Таван толгой-Сайншанд-Хөөт-Чойбалсан, Хөөт-	90%

					<p>Бичигт чиглэлийн төмөр замын шугамын чигийг тогтоох тухай тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 146 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>Төслийг түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээгээр, Засгийн газрын баталгаа гаргаж, хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2017 оны эхний улиралд багтаан гэрээ байгуулан ажил эхлүүлэх тухай тогтоолын төсөл боловсруулж яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлсэн.</p>		
			4. Хөөт-Бичигт чиглэлийн /234 км/ Барилгын ажлын явц, хувиар		<p>Монгол Улсын Их Хурлын 2014 оны 64 дүгээр тогтоолоор "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д тодотгол хийж Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн царигийн өргөнийг 1435 мм байхаар шийдвэрлэсэн. Энэ чиглэлд "Монголын төмөр зам" ТӨХК, БНХАУ-ын "Башинь төмөр зам" ХХК хооронд байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Хятадын Төмөр замын зураг төслийн гуравдугаар товчоогоор ТЭЗҮ болон зураг төслийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна. Түүнчлэн, Бичигт-Зүүн хатавч хилийн төмөр замын боомтын холболтын цэгийг тохиролцохоор хоёр улсын Гадаад хэргийн яамдаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байна. Бичигт-Зүүн хатавчийн хилийн боомтын төмөр замын бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх, барилгын ажлыг гүйцэтгэхэд хамтарч ажиллахаар Монгол Улсын Зам, тээврийн яам, ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн удирдлагатай 2015 оны 10 дугаар сард уулзаж, урьдчилан тохиролцсон бөгөөд хилийн боомтын холболтын цэгийг Монгол, Хятадын Гадаад хэргийн яамаар ахлуулсан ажлын хэсэг 2016 оны 5 дугаар сард Бичигт-Зүүнхатавч боомт дээр ажиллаж тохиролцсон. Одоо барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэснээр барилгын ажлыг эхлүүлэх болно.</p> <p>Төслийг түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээгээр, Засгийн газрын баталгаа гаргаж, хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2017 оны эхний улиралд багтаан гэрээ байгуулан ажил эхлүүлэх тухай тогтоолын төсөл боловсруулж, яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлсэн.</p>	90%	
8.6	ҮХЦБ-ын 5.3.1.4 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 120.3	Эрдэнэт-Овоотын дугаар шатны төмөр замын 3 үе суурь	Барилгын ажлын явц, хувиар	10 хувь	ТЗДТБХЗ Г, БТГ	<p>МУ-ын Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 327 дугаар тогтоол Эрдэнэт хотоос Овоотын уурхай чиглэлийн төмөр замыг зураг төсөл боловсруулах, барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр Концессын гэрээ байгуулах эрх олгосон. МУ-ын Засгийн газрын 2015 оны 10-р сарын 26-ны өдрийн 420 дугаар тогтоолоор</p>	90%

	дахь заалт	бүтцийн барилгын ажлыг эхлүүлэх				<p>Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Нортерн рейлвейз” ХХК-д олгосон. Одоо тус компани барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэснээр барилгын ажлыг эхлүүлэх болно.</p> <p>Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын чиг нь Эгийн голийн усан цахилгаан станцын төслийн авто зам болон агаарын шугамын чигтэй давхцалтай байгааг шийдвэрлэх ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна. Уг төслийн ТЭЗҮ-ийг энэ оны 12 дугаар сард дуусгахаар ажиллаж байна. Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын чигийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж яамдаас санал авахаар 2016.11.21-ний өдрийн 01/1741 тоот албан бичиг хүргүүлсэн. 2016 оны 12 дугаар сард багтааж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж 2017 оны 2 дугаар улиралаас барилгын ажлыг эхлүүлэх болно.</p>	
8.7	ЗГҮАХХАХТ-ний 107.2 дахь заалт	Мандал-Багахангай чиглэлийн Богдхан төмөр замын суурь бүтэц барих төслийг эхлүүлэх	1. Төслийн урьдчилсан судалгаа хийх	100 хувь	ТЗДТБХЗ Г, БТГ	<p>АХБ-аас Төслийн бэлтгэл техникийн туслалцаанд 1,5 сая ам.долларын санхүүжилтийг буцалтгүй тусламж олгох шийдвэрээ 2015.07.30-ны өдөр албан бичгээр мэдэгдсэн. Энэ дагуу техникийн туслалцааны төслийг эхлүүлэхээр АХБ-аас ирүүлсэн төслийн төлөвлөлтийн баримт бичгийг Англи хэлнээс орчуулан холбогдох санал, зөвлөмжийг боловсруулж АХБ-нд хүргүүлсэн. 2016 оны 2 сарын 23-ны өдөр Азийн хөгжлийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газарт ЗТЯ, АХБ-ны хооронд видео уулзалт зохион байгуулагдаж, төслийн бэлтгэл техникийн туслалцааг эхлүүлэх төлөвлөгөөний талаар хэлэлцсэн. Уулзалтаар Азийн хөгжлийн банкны санал болгосны дагуу төмөр замын трассын судалгааны ажлыг эхлүүлж, бусад судалгааны ажлыг гүйцэтгэх Зөвлөхийн сонгон шалгаруулалтыг нэгэн зэрэг явуулахаар тогтов. Үүний дагуу Азийн хөгжлийн банкнаас Богдхан төмөр замын төслийн ТЭЗҮ болон зураг төслийг боловсруулах Зөвлөхүүдийн ажлын даалгаврыг боловсруулж ирүүлсэнд 2016 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 06/59 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн Азийн хөгжлийн банкнаас чигийн судалгааны ажлын даалгаврын төслийг боловсруулж ирүүлсэнд тус яам холбогдох газруудаас саналыг авч чигийн судалгааны ажлын даалгаврын төсөлд тусган 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 02/114 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.</p> <p>Азийн хөгжлийн банкнаас чигийн судалгаа хийх компанийг сонгох шалгаруулахаар ажиллаж байна. Шалгарсан компани нь Богдхан төмөр замын чигийн судалгааны ажлыг боловсруулна.</p>	70%
			2. Техник эдийн			<p>Судалгааны ажил хийх сонгон шалгаруулалт явуулах эрхийг Азийн</p>	50%

			засгийн үндэслэл боловсруулах			хөгжлийн банкнаас ирүүлсэн. Тендер зарлагдсан. Сонгон шалгаруулалт явуулсны дараа техник эдийн засгийн үндэслэл боловсруулна.	
			3. Зураг төсөл хийх			Урьдчилсан байдлаар Богдхан төмөр замын 7 хувилбар бүхий чигийн зураг хийгдсэн байгаа. Судалгааны ажил хийх сонгон шалгаруулалт явуулах эрхийг Азийн хөгжлийн банкнаас ирүүлсэн. Тендер зарлагдсан. Сонгон шалгаруулалт явуулсны дараа зураг төсөл хийгдэнэ.	50%
			4. Барилгын ажлын явц, хувиар	5 хувь		Судалгаа болон техник эдийн засгийн үндэслэл хийгдсэний дараа барилгын ажил эхэлнэ. Судалгааны ажил хийх санхүүжилтийг Азийн хөгжлийн банкнаас гаргахаар шийдвэрлэсэн. Монгол Улсын 2016, 2017 оны төсвийн тухай хуульд Зам, тээврийн сайдын багцад барилгын ажлын санхүүжилт тусгагдаагүй тул бусад хөрөнгө оруулагчдад хандаад байна.	-
8.8	"Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"-ын 6.1.4 дэх заалт	Даланзадгад, Ховдын нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгон өргөжүүлэх	Барилгын ажлын явц, хувиар	10 хувь	АТБХЗХ, БТГ	<p>"Монгол Улсын Иргэний нисэхийн нисэх буудлуудыг 2025 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээ", "Ховд аймгийн нисэх буудлын барилга байгууламжийг өргөтгөх, их засвар хийх ажлын ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө, ажлын зургийн даалгавар"-ыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга 2016.05.04-ний өдөр баталсан.</p> <p>Ховд аймаг дахь нисэх буудлыг олон улсын 4С ангиллын нисэх буудал болгох ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжуудыг шинээр төлөвлөх ажлын ТЭЗҮ, ажлын зургийн даалгаврыг шинэчлэн баталсан. Нисэх буудлын барилга байгууламж, аэродромын зураг төсвийг 4С ангилалд нийцүүлэн боловсруулж, улсын экспертизээр баталгаажуулсан. Мөн Ховд нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилгын зураг төслийг боловсруулах даалгаврыг баталж, зөвлөхийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2 удаа зохион байгуулсан боловч төсөвт өртөг бага гэдэг шалтгаанаар компаниуд материал ирүүлээгүй.</p> <p>Төсвийн хүндрэлээс шалтгаалж санхүүжилт олдохгүй байгаа, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2018-2020 онд хэрэгжүүлэхээр, санхүүжилтийн эх үүсвэрийг 40 тэрбум төгрөгөөр тусгасан болно.</p> <p>Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад "Даланзадгад дахь нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх онгоцны буудал болгон шинэчлэн барих төсөл"-ийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн</p>	70%

					<p>хүрээнд зураг төсөл боловсруулах, барих-ашиглах-шилжүүлэх нөхцөлөөр барихаар туссан.</p> <p>Мөн Эдийн засгийн хөгжлийн яамнаас 2014 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан ЭЗХЯ, Сингапурын хөгжлийн агентлаг, Зам, тээврийн яам, Төрийн банк, ИНЕГ-ын болон бусад байгууллагуудын төлөөллүүд оролцсон хурлаас Өмнөговь аймгийн "Гурвансайхан" нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгох төслийг "Төр хувийн хэвшлийн түншлэл"-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, Эдийн засгийн хөгжлийн яам энэ ажлыг зохион байгуулахаар болсон.</p> <p>Өмнөговь аймгийн "Гурвансайхан" нисэх буудлыг "Олон улсын нөөц нисэх буудал" болгох ажлын Техник, эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө, ажлын зураг төсөл боловсруулах ерөнхий даалгавар"-г 2015 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.</p> <p>Уг даалгавраар тус нисэх буудлыг /аэродром нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын /ICAO/ шаардлагыг хангасан 4D зэрэглэл бүхий Боинг 767-300ER, Боинг747-400, Аэробус-340, 330 маягийн агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай, хөөрч буух зурвас нь голчийн гэрэлтүүлгийн системтэй байх, Нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга байгууламж нь цагт 500-аас багагүй зорчигчдод үйлчлэх хүчин чадалтай, 2 хүзүүвтэй, өргөтгөх боломжтой/ байхаар төлөвлөсөн.</p> <p>Энэхүү техникийн даалгаврын дагуу нисэх буудлын барилга байгууламжийн зураг төсөл, ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг Улсын төсөв, Концесс болон бусад зээлийн хүрээнд шийдвэрлүүлэхээр холбогдох тайлбар, танилцуулгыг бэлтгэж, Аж үйлдвэрийн яам, Сангийн яаманд танилцуулсан ч төсвийн хүндрэлээс шалтгаалан санхүүжилт олдоогүй.</p> <p>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Өмнөговь аймгийн "Гурвансайхан" нисэх буудлыг "Олон улсын нөөц нисэх буудал" болгох ажлыг 2017-2020 онд хэрэгжүүлэхээр, санхүүжилтийн эх үүсвэрийг 300 тэрбум төгрөгөөр тусгасан болно</p> <p>Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Ховд нисэх буудлыг олон улсын 4C ангиллын нисэх</p>
--	--	--	--	--	---



						буудал болгох нөөц нисэх буудал болгох ажлын ТЭЗҮ, зураг төслийг хийлгэх, Гурвансайхан нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгох зураг төсөв хийгдэхээр тус тус тусгасан.	
8.9	ЗГҮАХХАХТ- ний 108.29 дэх заалт	Ховдоос Завханы чиглэлийн Сархайрханы гүүр хүртэлх 130 км хатуу хучилттай замыг барих асуудлыг судалж шийдвэрлэх	Хатуу хучилттай авто зам барих судалгааны ажлыг боловсруулж, дүгнэлт гаргаж, цаашид авах арга хэмжээний талаарх шийдвэрийг гаргасан байна.	100 хувь	АЗБХЗГ БТГ	Мянгадын гүүрнээс Сархайрхан чиглэлийн 20 км хатуу хучилттай авто замыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014-2015 онд барьж ашиглалтад оруулсан. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тус яамнаас санал оруулаагүй. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эхний ээлжид аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох зорилтыг тавьсан бөгөөд энэхүү зорилтод дээрх чиглэлийн авто зам тусгагдаагүй. Тус чиглэлийн авто замын судалгааны ажлыг боловсруулахад шаардагдах хөрөнгө Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй тул хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн.	-
<b>Нийт</b>							<b>77.9%</b>

----oOo----